

АНУ-ын Хөнгөлөлтийн ерөнхий систем

1974 онд АНУ-н Конгресс өөрийн орны үйлдвэрлэгчдийн болоод хэрэглэгчдийн сонголтыг өргөжүүлэхийн сацуу хөгжиж буй орнуудад эдийн засгаа хөгжүүлэх боломжийг олгох зорилгоор АНУ-ын Хөнгөлөлтийн ерөнхий системийг санаачилсан.

Хөнгөлөлтийн ерөнхий систем буюу GSP хөтөлбөрийн хүрээнд 134 хөгжиж буй улс орон (BDCs) 3400 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг гаалийн татвараас чөлөөлөх хөнгөлөлтийг эдэлдэг байна. 1996 онд нэмжк 1450 нэр төрлийн бараа бүтээгдэхүүнийг гаалийн татваргүй нэвтрүүлэх эрхийг нэн буурай хөгжиж буй улс орнуудад (LDBDCs) олгосон.

Одоогоор Хөнгөлөлтийн ерөнхий системийн ашиг шимийг гүртэгч (ХЕС-г хүртэгч) нэн буурай хөгжиж буй улс орнуудын тоо 43-т хүрээд байна. Хөнгөлөлтийн ерөнхий системийн хүрээнд 2006 онд АНУ улсад нийт 32,6 тэрбум долларын импорт орсон бөгөөд энэ нь 2005 онтой харьцуулахад 22 хувиар өссөн үзүүлэлт юм. Хөнгөлөлтийн ерөнхий систем (GSP)-н нэгдсэн бараа бүтээгдэхүүний жагсаалтанд татвар ногдуулбал зохих бүтэн ба хагас боловсруулсан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгчид болоод газар тариалангийн, загасчлалын болон аж үйлдвэрлэлийн анхдагч бүтээгдэхүүнүүд багтдаг байна.

ХЕС(GSP)-ийн хүрээнд 2006 онд АНУ-ын импортлосон бараа бүтээгдэхүүний дийлэнх хувийг газрын тос, алт үнэт эдлэл, сайжруулсан зэсийн катод, метанол, хөнгөн цагаан бүтээгдэхүүн болон мөнгөн эдлэл эзэлж байна.

АНУ-руу 2006 онд Монголоос импортлосон бараа бүтээгдэхүүнд гянт, хуванцар болон хуванцар гэр ахуйн хэрэгсэл, жорлонгийн эд анги, хуванцар эд анги, хувцас болоод үслэг малгай зэрэг бүтээгдэхүүн багтаж байна.

ХЕС (GSP)-ийг хэрэгжүүлэхэд ХЕС-ийн дүрэмд зааснаар зарим нэг зүйл ангийн бүтээгдэхүүнийг хориглосон байдаг. Тухайлбал ноосоор хийсэн нэхмэл эдлэл, ноос, ургамалын гаралтай утас, бугуйн цаг, зарим төрлийн гутал, цүнх, ачаа тээш, ажлын бээлий, бөс бараа болоод арьс ширэн бүтээгдэхүүн багтдаг байна.

Аливаа бараа бүтээгдэхүүнийг АНУ-руу импортлоход ХЕС(GSP)-ийн татваргүй нэвтрүүлэх эрхийг хэрхэн авах вэ?

ХЕС(GSP)-г эдлэх импорт нь дараах шаардлагыг хангасан байна:

- Импортоор орж ирж буй бараа бүтээгдэхүүн нь ХЕС(GSP)-н бараа бүтээгдэхүүний жагсаалтад багтсан байх¹

- Бараа бүтээгдэхүүнийг ХЕС-г хүртэгч орноос шууд импортлосон эсвэл дамжин өнгөрөгч орноор дайран гарсан байж болох бөгөөд битүүмжлэгдсэн контейнерт тээвэрлэсэн байх.
- Нэр төрөл зүйл нь ХЕС-г хүртэгч оронд ургасан, үйлдвэрлэсэн, гаралтай байна.
- ХЕС-г хүртэгч орны хувьд бүтээгдэхүүний орцыг гаднаас импортлож байгаа тохиолдолд тухайн ХЕС-г хүртэгч улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний материалын нийт үнэ ба үйлдвэрлэлийн шууд зардлын нийлбэр нь тухайн бүтээгдэхүүний АНУ-д экспортлогдох үеийн үнэлсэн өртөгийн дор хаяж 35 хувьтай тэнцэх ёстой. Энэхүү 35 хувийн нэмүү өртөгийн шаардлагыг хангахын тулд бүтээгдэхүүн үйлдвэрлэхээр импортоор авч буй материалыг “үлэмж хэмжээнд хувиргасан” байх ёстой бөгөөд энэ нь шинэ өөр материал болж хувиран экспортлох гэж буй нэр төрлийн бүтээгдэхүүний орц болно гэсэн үг юм. “үлэмж хэмжээнд хувиргасан” гэдэг маань АНУ-ын гаалиас бүрэлдэхүүн хэсгийн материалыг өөр зүйл хэмээн ангилахыг хэлж байгаа юм.
- Экспортлогч эсвэл импортлогч нь тухайн бараа бүтээгдэхүүнийг ХЕС(GSP)-ийн хүрээнд гаалийн татваргүй нэвтрүүлэх хүсэлт гаргахдаа гаалийн мэдүүлэгийн маягтан дээр импортлон оруулж ирж буй барааг тодорхойлдог Барааны уялдуулсан системийн дугаарын өмнө “A”, “A+”, “A*” гэсэн үсэгийг тавих ёстой.

Хуулийн дхгуу өрсөлдөх хэрэгцээний хязгаарлалт

Өрсөлдөх хэрэгцээний хязгаарлалт (CNL) гэдэг нь ХЕС-ийн хүрээнд ХЕС-г хүртэгч улсад болон бараа бүтээгдэхүүн тус бүрт олгох хөнгөлөлтүүдэд хязгаар тавидаг юм. Аливаа бараа бүтээгдэхүүний өрсөлдөх хэрэгцээний хязгаарлалт (CNL) нь хэтэрсэн эсвэл энэ заалтыг хэрэгсэхгүй болгох зөвшөөрөл аваагүй тохиолдолд ХЕС-г хүртэгч улс нь тухайн бараа бүтээгдэхүүний хувьд ХЕС (GSP)-н эрхээ автоматаар алдахад хүрдэг. Харин ХЕС-г хүртэгч нэн буурай хөгжиж буй улс орнуудын (LDBDCs) хувьд энэхүү өрсөлдөх хэрэгцээний хязгаарлалт (CNL)-ыг автоматаар цуцалдаг.

Бүсийн нийгэмлэг дэхь ХЕС (GSP)-ийн хүлээн авагчдын орц нь орцын нэгтгэл байна

ХЕС (GSP) хөтөлбөрт Бүсийн холбооны гишүүн ХЕС-г хүртэгч улс оронд зориулсан тусгай заалт байдаг. ХЕС (GSP) –ийн дүрэмд зааснаар Бүсийн холбоог нэг улс хэмээн тодорхойлдог байна. Холбооны гишүүн болох хоёр ба түүнээс дээш улсад үйлвэдвэрлэсэн нэр төрлийн бүтээгдэхүүн нь гарал үүслийн дүрмийн шаардлагыг хангаж байвал татваргүй нэвтрэх бараа бүтээгдэхүүнд тооцогдоно. Аливаа ХЕС-г хүртэгч нэн буурай хөгжиж буй улс орон нь олны танил болсон Бүсийн холбооны гишүүн бол ХЕС-г хүртэгч нэн буурай бус хөгжиж буй улс орнуудтай хамтарч нэн буурай

хөгжиж буй улс орнуудад зөвшөөрөгдсөн 1400 бүтээгдэхүүнээс нэгийг хийж болно. Энэ бүтээгдэхүүн нь АНУ- уруу тухайн нэн буурай хөгжиж буй улсаас шууд тээвэрлэгдсэн тохиолдолд татваргүй нэвтрэх бараанд тооцогдоно.

ХЕС (GSP)-ээр батlamжлагdsan сүлжмэл гар урлалын зохицуулалт

ХЕС-г хүrtэгч 13 улс АНУ-ын “батlamжлагdsan сүлжмэл гар урлалын зохицуулалт” –тай байдаг бөгөөд эдгээр орнууд GSP-ийн татваргүй барааны нөхцлөөр хэд хэдэн гар урлалын бүтээгдэхүүн экспортлох боломжтой байдаг. Энэхүү гэрээгээр дараах бүтээгдэхүүн татваргүй бараанд тооцогдох бөгөөд тухайн ХЕС-г хүrtэгч улс нь эдгээр бүтээгдэхүүнийг батlamжилсан байх ёстой. Үүнд, гар хийцийн ардын урлагийн хэв шинжтэй хананд өлгөдөг зүйлс, гар хийцийн ардын урлагийн хэв шинжтэй дэрний уут, гараар нэхсэн шалны дэвсгэр зэрэг багтаж байна. Эдгээрээс төрөх татварын хэмжээ нь 3.8-4.3 хувиар хэмнэгдэж байгаа юм.

Илүү мэдээлэл хэрэгтэй бол

Доорхи хаягаар GSP хөтөлбөрийн гарын авлага болоод бараа бүтээгдэхүүний талаарх мэдээлэл аваарай

http://www.ustr.gov/Trade_Development/Preference_Programs/GSP/Section_Index.html